



КРЕДИТ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ББСБ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 10-ны өдөр

№ 2021/06-01

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2 сарын 10-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор зээлийн сунгалтын модуль нэвтрүүлж байгаатай холбогдуулан Тэнгэр Системс ХХК-тай Зээлийн сунгалтын модуль нэвтрүүлэхтэй холбоотой сар бүр төлдөг сарын хураамжид өөрчлөлт оруулах Нэмэлт гэрээ байгуулах зөвшөөрлийг олгож, Сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал Г.Тэлмэнд үүрэг болгосугай.
3. Энэхүү санал хураалтад сонирхлын зөрчилгүй этгээдүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурьдсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод Аудитын Хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ